



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар Б/101.

Өлгий

Шагнах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/99 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын тушаал гаргах /код 136/ журам”-ын 136.4 дэх хэсгийн 136.4.2-ын “в”, мөн даргын 2011 оны 38 дугаар тушаалаар баталсан “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /код 900/ журам”-ын 900.3.4-ийн “д”, Цагдаагийн газрын дотоод журмын 14.1, Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 32 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2016 оны ажлын үр дүнгээрээ хамт олноо хошуучлан ажиллаж, байгууллагын оны хөдөлмөрийн тэргүүний алба хаагч, ажил, мэргэжлийн шилдэг болон онцлох алба хаагч, тэргүүний тасгаар шалгарсан хамт олны нэрсийг нэгдүгээр хавсралтаар, Цагдаагийн газрын баярын бичгээр шагнуулах алба хаагч, албан тушаалтны нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Байгууллагын хөдөлмөрийн тэргүүний алба хаагч, ажил, мэргэжлийн шилдэг болон онцлох алба хаагч, тэргүүний тасаг, хамт олон, цагдаагийн газрын баярын бичгээр шагнуулсан алба хаагч, албан тушаалтан нарт хүндэтгэл үзүүлэх 700.000 /долоон зуун мянга/ төгрөгийг хоол, хүнсний зардлаас зохих журмын дагуу бодож гаргахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн дэслэгч Б.Батсүх/-т зөвшөөрсүгэй.

3. Шагнагдсан алба хаагч, албан тушаалтан, хамт олонд баяр хүргэж, ажлын амжилт хүссүгэй.

4. Хөдөлмөрийн тэргүүний алба хаагч, ажил, мэргэжлийн шилдэг болон онцлох алба хаагч, тэргүүний тасгаар шалгарсан хамт олны зургийг Цагдаагийн газрын “Хүндэт самбар”-т байршуулж, алдаршуулсугай.

5. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Т.Ганбат/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



М.БАТБОЛД